



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР**

**ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД САЛБАР ДУНДЫН
БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОЛЦОО,
ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

ХАМТАРСАН БАГ


- ХНХС, ХЗДХС, ЭМС-ын 2017 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/173, А/259, А/380 тоот хамтарсан тушаалаар “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ыг баталсан.

Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн №29 дүгээр тогтоолоор “Хамтарсан баг” байгуулж, Дархан сумын хамтарсан багийн бүрэлдэхүүн, багуудын хамтарсан багийн бүрэлдэхүүнийг баталсан.

Цагдаагийн
байгууллагаас Шарын
гол сум дахь сум дундын
цагдаагийн хэлтсийн
хэсгийн байцаагч-2,
Орхон, Хонгор сумдын
хэсгийн төлөөлөгч-2, 1-
18 дугаар багийн хэсгийн
байцаагч-18, нийт 22
алба хаагч хамтарсан
багийн гишүүнээр
ажиллаж байна.

Энэ оны эхний 9 сарын
байдлаар цагдаагийн
байгууллагад 611 гэмт
хэрэг бүртгэгдэж урьдч
оны мөн үеэс 1 хувиар
буурсан үзүүлэлттэй.
Үүнээс гэр бүлийн
хүчирхийллийн улмаас
үйлдэгдсэн гэмт хэрэг 51
бүртгэгдэж урьд оны мөн
үеэс 64.5 хувиар өсч нийт
гэмт хэргийн 8.3 хувийг
эзэлж байна.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ



Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд

- **Хохирогчийг хамгаалалтад авсан:**
- **2018 онд -50**
- **2019 онд -121**
- **Аюулын зэргийн үнэлгээ хийсэн:**
- **2018 онд -28 удаа**
- **2019 онд -51 удаа**

Зөрчил шалган шийдвэрлэх/ГБХ/

• **Эхний 9 сард**

• **2018 онд-48
зөрчил**

• **2019 онд -90
зөрчил**

• **АЗҮнэлгээ-
103**


Эхний 9 сард

Шүүхээс
баривчлах шийтгэл
ногдуулсан


• **2018 онд-65
хүн**

• **2019 онд -88
хүн**

ГБХ-ийн гэмт хэргийн үйлдэгдсэн байдал /сүүлийн 5 жилээр/




ГБХ-д өртөж хохирсон иргэд




Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчийн мэдээлэл

Д/д	Гэмт Он	2015. 09	2016. 09	2017. 09	2018. 09	2019. 09
1	ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн хэрэг	27	41	36	31	51
2	эмэгтэй	20	31	33	25	35
3	18 хүртэл насны хүүхэд	4	2	1	3	2
4	Биемахбодийн хүчирхийлэлд өртсөн	21	29	32	22	44
5	Гэмтсэн	24	31	35	24	41
6	Нас барсан	2	1	-	-	3
7	Хүчирхийлэлтэй харилцааны түүх /0-1/	23	25	31	23	47
8	Давтамж /жилд 1-2 удаа/	20	22	24	25	49
9	хохирсон хүн: эхнэр	14	21	25	15	24
10	Хамтран амьдрагч	5	2	6	8	15
9	эрхэлсэн ажилгүй	16	21	18	17	28


ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙГ БАГААР НЬ АВЧ ҮЗВЭЛ:



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЗӨРЧЛИЙГ БАГААР НЬ АВЧ ҮЗВЭЛ:



ХҮҮХЭД ХОЛБОГДСОН БОЛОН ӨРТӨЖ ХОХИРСОН ГЭМТ ХЭРЭГ /2019 ОНЫ ЭХНИЙ 9 САР/



ХАМТАРСАН БАГТ АЖИЛЛАСАН ТАЛААР:

Хамтарсан багийн гишүүд 2019 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд хамтарсан багийн хуралд 51 удаа оролцож, 154 удаа аюулын зэргийн үнэлгээ хийж, нийт 85 иргэнийг хамтарсан багийн үйлчилгээнд хамруулсан.

Хууль зүй дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/63, А/481, А/106 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн зөрчил гаргаж баривчлагдсан 88 хүнд хувийн хэрэг нээж, 640 цагийн албадан сургалт зохион байгуулсан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 112 хүнд хууль зүйн зөвөлгөө өгч, “Тусламжийн хуудас” 300 хүнд өгч, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг эрчимжүүлж ажилласан.

Хамтарсан багийн ажиллах журмыг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажлын талаар

- Дархан сумын 1, 2, 3, 6, 7, 8 дугаар багт “**Миний баг-Амгалан баг**” арга хэмжээг зохион байгуулж 395 иргэн, 480 сурагчдад сургалт зохион байгуулж, 51 айл өрхөөр зочилж, амьдрал ахуйтай нь танилцан, хүчирхийлэл үйлдсэн болон үйлдэж болзошгүй мөн архины хамааралтай 36 хүнтэй ганцаарчлан уулзаж зөвлөгөө өгч, зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтанд 21 хүнийг хамруулж, 275 хүнээс санал асуулга авч, эрсдэлтэй 8 хүүхдийг илрүүлэн хамтарсан багт холбон зуучилж, хамтарсан багаар тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан.

МИНИЙ БАГ-АМГАЛАН БАГ /1-8-р БАГ/



•“Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлье” сэдвийн хүрээнд **“Нээлттэй хаалганы өдөрлөг”**-ийг Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдад зохион байгуулж 1023 иргэн хамрагдаж, санал, хүсэлт, мэдээлэл 45-ийг ирүүлснээс газар дээр нь 20 асуудлыг шийдвэрлэн, хууль тогтоомжийг сурталчилж, 800 ширхэг гарын авлага зөвлөмж тарааж, хамтарсан багийн гишүүдэд сургалт зохион байгуулж ажилласан.



- “ГЭР БҮЛ
ХҮҮХДИЙГ
ХАМГААЛЪЯ”
АРГА ХЭМЖЭЭГ ДАРХАН
СУМЫН 9-16,
МАЛЧИН, ӨРГӨӨ БАГИЙГ
ХАМРУУЛАН ЗОХИОН
БАЙГУУЛЖ ЭХЭЛСЭН.



Аймгийн ГХУСАЗСЗ, ГБХЗХГ, БСУГ, Насан туршийн боловсрол төв, Залуучууд хөгжлийн төв, Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгтэй хамтран эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор “Нэг тэрбумаараа тэмцье-2019” арга хэмжээг “Эмэгтэйчүүдийн эв нэгдлийн хана” уриан дор зохион байгуулж, 36 аж ахуйн нэгж байгууллагаар орж, хүчирхийллийн талаар танилцуулга мэдээлэл хийж, арга хэмжээг 680 орчим иргэдийн оролцоотойгоор зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийг сурталчилсан гарын авлага, зурагт хуудас 500 ширхэгийг тарааж нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.



- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, түүнийг дагалдан гарсан журмуудыг хэрэгжүүлэх, энэ чиглэлээр алба хаагчдыг чадавхижуулах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам, IDLO Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагаас эмхлэн гаргасан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага” номыг хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч 20 алба хаагчдад өгч, “Гэр бүлийн хучирхийлэлтэй тэмцэх тухай, хууль, журам” файлыг Цагдаагийн газрын мэдүүлэг авах 5 өрөө, Мөрдөн байцаах тасаг, Шуурхай удирдлагын тасаг, НХЖХТ-ийн алба хаагчдын өрөөний компьютеруудад суулгаж, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллалаа. Алба хаагчдад 5 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 370 алба хаагч хамрагдаж, ажил үйлчилгээндээ болон ахуйн хүрээнд энэ төрлийн зөрчил гаргахгүй байх талаар баталгаа гарган хэрэгжүүлэн ажилласан.



- Дархан-Уул аймаг дахь Анхан шатны шүүхийн Тамгын газартай хамтран "Гэр бүлийн холбогдолтой хэрэг, маргааныг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх явцад хүүхдийн эрх ашгийг хамгаалах нь" сэдэвт хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулсан.
- ХЭҮТ-өөс "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэнд мониторинг 2 удаа хийхэд хамтран ажилласан.



- Аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол хүргэх зорилгоор хүүхэд хамгаалал, замын хөдөлгөөний аюулгүй байдал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хулгайлах, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 200x50 см-ийн хэмжээтэй зурагт хуудас 10 ширхгийг хэвлүүлэн Дархан сумын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг том оврын 5 автобусанд байршуулан ажилласан.
- Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, Хамтарсан багийн үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 12 удаагийн мэдээллийг иргэдэд хүргэсэн.



ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

- Багийн нийгмийн ажилтан солигддог
- Хамтарсан багийн гишүүдэд урамшуулал, дэмжлэг байхгүй.
- Хамтарсан багийн гишүүдийн идэвх санаачилга сул, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй /ажилгүйдэл, архины хамааралтай г.м/ олон асуудал гардаг.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

- Хамтарсан багийн үйл ажиллагаанд зарцуулагдах санхүүгийн асуудал хүндрэлтэй.

/хоол хүнс, тээвэрлэх унааны зардал..../

- Өрхийн эмчийн оролцоо хангалтгүй, /ажил амжихгүй байна гэх /
- Хуралд оролцогч хохирогч, холбогдогчдын зүгээс сэтгэл зүйн хувьд таагүй, бэлтгэлгүй байдаг.

САНАЛ, АНХААРАХ АСУУДАЛ

- Жил бүрийн төсөвт, зарцуулагдах хөрөнгийг тусгах
- Хамтарсан багийн хурлыг төлөвлөж, оролцогчдыг бэлтгэх, мэдээллээр хангасны дараа хуралдуулж байх
- Хамтарсан багт гэр бүл судлаачийг оролцуулах
- Хамтарсан багийн гишүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах
- Багийн Засаг даргаас хүчирхийлэл үйлдэгчид тавих хяналтыг сайжруулах
- Бага насны хүүхэд төөрсөн, эрэн сурвалжлагдсан тохиолдол бүрт багаас идэвх санаачилгатай хамтарч ажиллах

САНАЛ, АНХААРАХ АСУУДАЛ

- Хүчирхийлэл үйлдэгдсэн байдлаар нь “Зорилтот баг”-ийг сонгон 2-3 баг хамтран урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах хуулиар үүрэг хүлээгчдийн салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, туршлага солилцох, чадавхижих
- Багийн иргэдийн ажилгүйдэл, согтууруулах ундааны хэрэглээг багасгах чиглэлээр санал санаачилга гаргаж ажиллах
- Ажлын байран дээр нь чадавхижуулах сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд хамгааллын чиглэлээр хийсэн ажлыг чанар, үр нөлөөг дээшлүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
- Хамтарсан багийн гишүүдэд хүлээлгэх хариуцлагыг сайжруулах



**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА.**